



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар A/434

Улаанбаатар хот

Налайх дүүргийн 2 дугаар хорооны
“Амь эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төвийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,399,484.80 (гурван сая гурван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун наян дөрвөн төгрөг наян мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн 2 дугаар хорооны “Амь эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төв (Ц.Оюунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 9 нэр төрлийн 3,399,484.80 (гурван сая гурван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун наян дөрвөн төгрөг наян мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Налайх дүүргийн 2 дугаар хорооны “Амь эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төв (Ц.Оюунтунгалаг)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001183

